

Хотын Ардын боловсролын байгууллагын үүсэл

1921-3-31-энд Дотоод яамны аппаратад сургуулийн хэлтэс анх байгуулагдсан байна.

1924-4-12-онд Улаанбаатар хотод багш нарыг бэлтгэх сургуулийг байгуулжээ. /Оюутны/ 1927-9-9-энд Засгийн газрын 31 дүгээр хурлын 3 дугаар зүйлээр оюутны ба нягтлан бодохын сургуулийг нэгтгэсэн юм.

1925 онд нийслэл Амгаланбаатарын бага сургууль, нийслэлд байсан Дэлгэр их уулын / их шавийн / аймгийн бага сургуулиудад 230 хүүхэд суралцаж, Нийслэлийн дунд сургууль, оюутны сургууль, төв клубийн сургууль, гаалийн сургууль, хоршооны сургууль, гэх мэтийн сургуулиудад бий болж түүнд 469 сурагчид байсны гадна нийслэлийн орос сургуульд 469 хүүхэд суралцаж байв.

1926 онд нийслэлийн сургуулиудаас зөвлөлт, герман, франц, мэтийн орнуудын олон сургуульд 253 хүн явжээ.

1927-12-16-анд Засгийн газрын 4 дүгээр хурлын 1 дүгээр зүйлээр Улаанбаатар хотод 5200 хүүхэдтэй 1 бага сургууль, 1928-8-1-нээн 50 хүүхэдтэй бага сургууль 1-чийг байгуулахаар тогтоожээ.

1930 онд Улаанбаатар хотод анх удаа хүүхдийн цэцэрлэг байгуулсан бөгөөд 1939-1940 онд тус улсад хүүхдийн цэцэрлэг 6 ажиллаж 91 хүүхэдтэй байсан байна.

1936-2-14-энд Сайд нарын Зөвлөлийн 10 дугаар тогтоолоор улс нийтээр дагаж хэрэгжүүлэх үндэсний үсгийн нэгдмэл цагаан толгойг 29 толгой үсэгтэйг ээр батлан тогтоож урьд хэрэглэж байсан олон зүйлийн цагаан толгойг хүчингүй болгожээ.

1939-оны 3 дугаар сард хуралдсан улсын 22 дугаар бага хурлын тогтоолд бага сургуулийн зохион байгуулалтыг тогтмол ангийг 4 жилийн хугацаагаар суралцах 4 анги бүхий сургуулиар батлахын тулд нийт сургуулиудын 4 дүгээр ангийн өргөтгөн байгуулах, дунд зохион байгуулалтыг 6 анги бүхий сургуулиар баталж, одоогийн 3 ангитай сургуулийг 4 ангитай болгох , 4 ангитай бүх сургуулийг 5, 6 дугаар ангитай болгохоор заан тогтоосон юм. Улаанбаатар хотод оройн түр сургууль зохион байгуулахаар заажээ.

Сайд нарын Зөвлөлийн 1940 оны 27 дугаар хурлаар Латин үсгийг үндэс болгож, шинэ монгол үсэг зохион боловсруулах комиссыг Ю. Цэдэнбал даргатайгаар байгуулсан.

1940 онд Сайд нарын Зөвлөлийн 34 дүгээр хурлаар монгол улсын дотор араб тоог хэрэгжүүлэхээр тогтоож, нийт хүмүүсийг араб тоонд сургах арга хэмжээ авсан байна.

1944 онд Сайд нарын Зөвлөлийн 4 дугаар тогтоолд Улаанбаатар хотод хүүхдийн цэцэрлэг 12, түүний хүүхэд 435 гэжээ.

1945-4-20-онд Сайд нарын Зөвлөл, Намын Төв Хорооны 26,.24 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлээр 1945, 1946 оны хичээлийн эхлэн 4, 7, 10 дугаар анги төгсөгчдөөс заавал төгсөлтийн шалгалт авч байх тухай журам тогтоосон

1955-7-9-энд Сайд нарын Зөвлөл, Намын Төв хорооны 289/167 дугаар тогтоолоор 8-12 насны хүүхдийг нийтээр нь заавал анхан шатны боловсролтой болгох ажлыг 1955-9-1-нээс Улаанбаатар хотод явуулахаар тогтоожээ. 1958-1-1-нээс ойн сургууль байгуулсан.

Сайд нарын Зөвлөлийн 1958-6-27-ний 211 дүгээр тогтоолоор сургуулийн насны хүүхдийн нийтээр 7 жилийн боловсролтой болгох, ажлыг Улаанбаатар хотод 1958-9-1-нээс явуулахаар заасан байна.

1963-10-16-анд Сайд нарын Зөвлөлийн 48 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын 1 дүгээр сургуульд хичээллэж байгаа хараагүй дүлий, багшийн сургуульд хичээллэж байгаа хэлгүй, дүлий хүүхдийн ангийг нэгтгэн өргөтгөж 1964/1965 оны хичээлийн жилд дотуур байртай, болгон байгуулахаар заажээ.

1965-5-19-энд Сайд нарын Зөвлөлийн 171 дүгээр тогтоолоор орос хэл дээр хичээллэх 1 дүгээр ангийг 1965/1966 оны хичээлийн жилээс эхлэн Улаанбаатар хотын 2 дугаар дунд сургууль дээр байгуулж 1 дүгээр ангийг жил бүр 4 бүлэгтэй, бүлгийн сурагчдын тоог 30-аар тогтоосон байна.

1968-12-26-энд Сайд нарын Зөвлөлийн 437 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын 2 дугаар дунд сургуулийн дэргэдэх орос хэл дээр хичээллэж байгаа бага ангийг 23 дугаар дунд сургуульд шилжүүлж, уг сургуулийг 1969/1970 оны хичээлийн жилээс эхлэн, орос хэл дээр дунд сургууль болгон өөрчилж, тус сургуулийн 1 дүгээр ангийн элсэлтийг тус бүр 30- аас дээшгүй сурагчидтай байхаар 4 бүлэг болгон ажиллуулахаар тогтоосон юм. Улаанбаатар хотод 14 кабинет лабораторитой нэг ээлжид 280 хүүхэд хичээллэдэг залуу техникчдийн ордон баригдсан.

1975-4-18-анд сайд нарын Зөвлөлийн 192 дугаар тогтоолоор Улаанбаатарт 1975 оноос эхлэн 8 жилийн хугацаатай хөгжмийн оройн сургууль байгуулж нээхээр тогтоожээ Улаанбаатар хотын дээд, тусгай мэргэжлийн дунд сургуулиудад 16000 гаруй, ерөнхий боловсролын 68 сургуульд охид хөвгүүд сурч 4 хүний нэг нь сургуульд суралцаж 5 хүний нэг нь дээд дунд шатны боловсрол эзэмшиж байна гэжээ.

1941-6-27-онд сайд нарын Зөвлөлийн 31 дүгээр хурлын 4 дүгээр зүйлээр Улаан-үд хотод байгаа багш нарыг бэлтгэх сургуулийг Улаанбаатар хотод татан ирүүлж 1941-7-1-нээс багш нарыг бэлтгэх болсон